



Монгол Улсын
Засгийн Газар

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
“ЯДУУРЛЫН СУДАЛГАА, ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ
ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ



Mongolia

**МОНГОЛ УЛСАД ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭДИЙН
ЗАСАГ, НИЙГМИЙН ОРОЛЦООГ
САЙЖРУУЛАХ НЬ:
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА
ХЭТИЙН ТӨЛӨВ**

*Кристофер Касобон
НҮБХХ-ийн Зөвлөх*

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
2010

Энэхүү ажлыг НҮБХХ-ийн Зөвлөх Кристофер Касобон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ)-ны захиалгаар Монгол Улс дахь НҮБХХ-ийн Хүний хөгжил ба Мянганы хөгжлийн зорилтын хөтөлбөрийн ажилтан П.Цэцгээ, Хүний хөгжил ба Мянганы хөгжлийн зорилтын хөтөлбөрийн багийн ахлагч Ж.Должинсүрэн, Төслийн үндэсний менежер А.Солонго, болон Үндэсний зөвлөх Н.Энхжаргал нарын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв.

Зохиогчтой ssasaubon@hotmail.com хаягаар холбоо барьж болно.

Монгол Улсын Засгийн газар нь НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх” төслийн хоёрдугаар үе шатыг (ЯСХЭДБХ төслийн 2-р үе шат) хэрэгжүүлж эхлээд байна. Уг төслийн бодлогын агуулга нь шинээр батлагдсан эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж 2015 он гэхэд ядуурлыг 2 дахин бууруулах зорилт бүхий Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-той уялдсан байна. Нөгөөтэйгүүр, ҮХЦБ-ын хэрэгжилт нь ядуурлыг бууруулах бодлогын талаар илүү даацтай тоо мэдээлэл, бодлогын дүн шинжилгээ болон бодлого, хөтөлбөрийн менежмент хийх өндөр чадавхийг шаардаж байна.

ЯСХЭДБХ төслийн 2-р үе шат нь ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулахын тулд ядуурал, хөдөлмөр эрхлэлт болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, мэдээллийг сайжруулах, түүнчлэн хүний хөгжлийн үзэл баримтлалыг ашиглах үндэсний чадавхийг бэхжүүлэх явдлыг үргэлжлүүлэн дэмжиж байна. Төсөл нь ядуурлын зураглал гаргах (1-р бүрэлдэхүүн хэсэг), хөдөлмөрийн статистикийн үндсэн тогтолцоо болох ажиллах хүч ба цаг ашиглалтын тоо мэдээллийг шинэчлэх (2-р бүрэлдэхүүн хэсэг), 2010 оны Хүний хөгжлийн үндэсний илтгэл болон ядуурлын бодлогын судалгаа хийх (3-р бүрэлдэхүүн хэсэг), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, эдийн засгийн амьдралд оролцуулах бодлого, хөтөлбөрийн цар хүрээг сайжруулах (4-р бүрэлдэхүүн хэсэг) ажлыг дэмжсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр тутмын амьдралд утга учиртай оролцох таатай нөхцөл бүрдүүлэх тал дээр Монгол Улсын Засгийн газар хүчин чармайлт гаргаж байна. Тийм ч учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд оролцуулах талаар өнөөгийн үндэсний бодлогыг бэхжүүлэх нь НХХЯ-ны эн тэргүүнд хийх ажлуудын нэг болж байна. Үүний тулд, Монгол Улсын Их хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг 2008 онд соёрхон баталжээ. НҮБ-ын энэхүү конвенцид нэгдэн орсны дагуу НХХЯ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үүрэг хариуцлага хүлээж байгаа билээ. Тиймээс НХХЯ-наас өнөөгийн үндэсний бодлогын цар хүрээг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн агуулгад нийцүүлэн хянахад дэмжлэг үзүүлж, улмаар одоогийн бодлогын хүрээг бэхжүүлэх зөвлөмж боловсруулахыг санал болгосон юм.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв

**НҮБХХ-ИЙН “ЯДУУРЛЫН СУДАЛГАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ - II ҮЕ ШАТ**

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам (НХХЯ), 104 тоот,
Засгийн газрын 2-р байр, Нэгдсэн үндэстний гудамж -44,
Улаанбаатар хот-15160, Монгол улс,
Утас/Факс: (976) 11 318637
Утас: (976) 11 319177
Цахим шуудан: pgef2sectra@gmail.com

2010 оны 9-10 дугаар сар

DDC
362.4
C-29

ISBN 978-99962-56-18-9

Энэхүү тайланд дурьдсан тайлбар, дүгнэлт зэрэг нь зохиолчийн хувийн үзэл санаа бөгөөд тэдгээр нь НҮБХХ болон НХХЯ-ны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гарчиг

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв

Хамтран хэрэгжүүлэгч талууд

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ) ба Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ).

Ерөнхий тойм

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь үндэсний болон орон нутгийн түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших боломж бололцоог сайжруулж, тэдний чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих талаар НҮБХХ/НХХЯ-наас гаргаж буй санаачлага дээр тулгуурлав.

Энэхүү тайлан нь таван үндсэн хэсгээс бүрдэнэ:

- Нэг дэх хэсэг нь алсын хараа, зорилго, зорилтууд
- Хоёр дахь хэсэг нь хөгжлийн бэрхшээлийн тухай тодорхойлолт
- Гурав дахь хэсэг нь Монгол Улсын хууль тогтоомж нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид хэрхэн нийцэж байгаа байдал
- Дөрөв дэх хэсэг нь НҮБ-ын конвенцийн гол заалтуудыг Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулан, холбогдох яамдад өгөх зөвлөмжүүд
- Сүүлчийн хэсэг нь үндэсний бага хурал, дугуй ширээний ярилцлага болон шинэ технологи ашиглаж тэдгээр мэдээллийг түгээх үед орон нутгийн түвшинд туршсан янз бүрийн арга замуудад анхаарал хандуулах болно.

ГАРЧИГ

Удиртгал.....	1
I Хөтөлбөрийн стратеги, зорилго ба зорилт.....	2
I. 1. Алсын хараа	2
I. 2. Зорилго ба зорилтууд	2
II Тодорхойлолтууд	3
II.1 Хөгжлийн бэрхшээлийн тухай тодорхойлолт.....	3
II.2 НҮБ-ын Конвенцид ХБХ-ийг тодорхойлсон нь.....	3
II.3 Олон улсын түвшинд хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлийн ангилал (ДЭМБ).....	3
III Монгол Улсын хууль тогтоомжууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид хэрхэн нийцэж буй байдал	4
IV ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн гол заалтуудыг Монгол Улсын хууль, тогтоомжтой харьцуулан холбогдох яамдад өгөх зөвлөмжүүд	7
IV. 1 Хүртээмж.....	7
IV. 1.1 Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжуудын харьцуулалт.....	7
IV.1.2 Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яаманд өгөх зөвлөмж	8
IV. 2. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө	8
IV. 2. 1 Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллээр хангагдах асуудлаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжид хийсэн харьцуулалт	8
IV. 2. 2 НХХЯ-нд өгөх зөвлөмж	10
IV. 3 Боловсрол	10
IV. 3. 1 ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Боловсролын тухай хуультай харьцуулах нь.....	10
IV. 3. 2 БСШУЯ-нд хүргэх зөвлөмж	14
IV. 4. Эрүүл мэнд, нөхөн сэргээлт	17
IV.4.1 ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын эрүүл мэнд, нөхөн сэргээлтийг тухай хуультай харьцуулах нь	17
IV.4. 2 Эрүүл мэндийн яаманд хүргэх зөвлөмж.....	19
IV. 5 Ажил, хөдөлмөр эрхлэлт.....	20
IV.5.1 Хөдөлмөр эрхлэлтийн асуудлын талаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын дотоодын хууль тогтоомжтой харьцуулах нь	20
IV. 5. 2 Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргэх зөвлөмж.....	22
IV. 6 Хуулийн хэрэгжилт, мониторингийн талаар өгөх зөвлөмж	22
V Үр дүнг хэвлэн нийтлүүлэх	26
Дүгнэлт.....	27
Хавсралтууд	28

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблей 2006 оны 12-р сарын 13-нд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг баталсан. Өнөөгийн буюу 2010 оны 11-р сарын байдлаар дэлхийд 700 сая гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ) байна. Монгол Улсад 100 000 ХБХ (ҮСХ-ны мэдээгээр 2008 оны сүүлээр 79 000 хөгжлийн бэрхшээлтэй хүн албан ёсоор бүртгэгдсэн бөгөөд үүнээс олон ч байж магадгүй) байна. Энэ нь Монголын нийт хүн амын 3.8 хувь бөгөөд үүний талаас илүү хувь нь хот суурин газар амьдарч байна.

Монгол Улс ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг 2008 оны 12-р сарын 19-ны өдөр соёрхон баталжээ. Ингэснээр Монгол Улсын Засгийн газар нь ХБХ-ийн сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг эрхийг багтаан нийгэмд үр бүтээлтэйгээр бүрэн оролцох боломжийг баталгаажуулах, дэмжихээ хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм.

Хүртээмж болон чанарын талаас нь өргөн утгаар авч үзвэл энэхүү баримт бичиг нь Монгол Улс дахь ХБХ-ийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, бүрэн чадвартай болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоорондын эв нэгдлийг хууль эрх зүйн, нийгмийн болон сэтгэл зүйн хандлагаар өөрчилж бэхжүүлэх боломжийг илэрхийлэх болно.

ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үзэл баримтлалыг хүний үндсэн эрх, эрх чөлөө, ойлголт, хүлцэл болон эв нэгдэлд анхаарах, түүнчлэн зан үйл, хандлага, үнэт зүйлсээсээ хуваалцах явдал гэж ойлгож болно. Энэ нь нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн оролцоог хангах, мэдээлэл хуваалцах болон мэдээллийн урсгалыг чөлөөтэй болгохоос эхлэх бөгөөд хөгжлийн бэрхшээл гэдэг нь зөвхөн нүдэнд үзэгдэх ялгааны тухай биш, харилцан ойлголцол, хамтын ажиллагааны зарчмаар зөрчилдөөнийг шийдвэрлэх, харилцан ойлголцлыг дэмжих эерэг, эрч хүчтэй оролцооны үйл явц юм.

Ерөнхийдөө, хөгжлийн бэрхшээлийн асуудал нь олон талтай бөгөөд үүнийг зөвхөн бие эрхтэний болон оюун санааны хомсдол талаас нь, эсвэл дан ганц сэтгэл зүйн хэрэгцээ шаардлага гэж үзвэл стратегийн алдаа болно. Энэ асуудлыг нийгэм-эдийн засаг, нийгмийн болон соёлын түвшинд авч үзэх нь чухал.

ХБИ-ний нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын хууль нь ХБХ-ийн эрх зүйн хүрээг тодорхойлж байна. Монгол Улсын Их Хурлаас уг хуулийг 1995 онд баталж, 1998 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү хуулийн хэрэгжилтийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ) хариуцан ажилладаг. Уг хуульд зааснаар төрөлхийн болон олдмол бие махбодь, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өвчин, ослын улмаас хөдөлмөрийн чадвар нь хязгаарлагдсан хүмүүс, хэл, хараа, сонсгол, биеийн болон оюун ухааны бэрхшээлтэй гэж оношлогдсон хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлж байна.

I. ХӨТӨЛБӨРИЙН СТРАТЕГИ, ЗОРИЛГО БА ЗОРИЛТ

I. 1. Алсын хараа

Энэхүү баримт бичигт санал болгож буй алсын хараа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх хүртээмж, эрүүл мэнд, нийгмийн боломжийг сайжруулах зорилготой бөгөөд Монгол Улсад дараах зорилт бүхий үр дүнтэй хөтөлбөрүүдийг бүх нийтэд зориулж боловсруулах боломж гэж үзвэл зохино. Үүнд:

- Оролцооны арга барилыг хөгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлийн асуудалд оролцогч талуудын хамтын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх;
- Тэргүүн туршлага нэвтрүүлэх, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- Ойлголт, мэдлэгийг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх бүсийн, үндэсний болон олон улсын үйл ажиллагаанд шинэчлэгчийн үүрэг гүйцэтгэх;
- Холбогдох бүх талуудын хамтын ажиллагаа, сүлжээ холбоог хөхиүлэн дэмжих;
- Засгийн газрын бүтцийг зөвлөмжийн дагуу ялангуяа эрх зүй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбарт илүү үр дүнтэй ажиллаж чадахаар боловсронгуй болгохыг дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд татан оролцуулах талаар үндэсний бодлогын хүрээг бэхжүүлэх;

Санал болгож буй ХБХ-т зориулсан боловсрол, сургалтын хөтөлбөр нь одоогийн багшлах болон сургалтын аргыг шинэ арга барил, техник (сэтгэл зүйн, сурган хүмүүжүүлэхүйн, эрүүл мэндийн, нийгмийн арга барил болон шинэ технологи)-тэй хослуулах аргад суурилсан болно.

I. 2. Зорилго ба зорилтууд

Энэхүү баримт бичгийн зорилго нь хүүхэд, залуус, насанд хүрэгчдийн НҮБ-ын Ерөнхий ассемблейгаас 1975 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” Тунхаглал болон 2007 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенци”-д заасан эрхээ эдлэх чадварыг дээшлүүлэх явдал юм. Энэхүү баримт бичгүүдийн зорилт нь:

- Монгол Улс дахь ХБХ-ийн эрхийг эдлүүлэхийн тулд улс төрийн болон хууль, эрх зүйн хүрээг сайжруулах;
- Ялгаварлан гадуурхалт, нийгмээс гадуурхах байдлыг багасгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар үг дуугүй өнгөрөх явдлыг таслан зогсоох нь үндэсний хэмжээний чухал асуудал гэж үзэж компанит ажлыг зохион байгуулах, идэвхижүүлэх;
- ХБХ-ийн эрхийг хамгаалах, хүндэтгэхэд хувь нэмэр оруулах эерэг хандлагыг бий болгохын тулд судалгаан дээр суурилсан харилцаа холбоог бэхжүүлэх тал дээр иргэний нийгэм, Монгол Улсын Засгийн газарт туслах;
- ХБХ-ийн эрхийг эдлүүлэх, гадуурхалт, сөрөг хандлагыг бууруулах таатай орчин бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлийг хүний эрх гэдэг үүднээс нь авч үзэж сургалтын хөтөлбөрт оруулах;
- Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх;

Түүнчлэн энэхүү баримт бичигт Монгол Улс дахь ХБХ-ийг эдийн засаг, нийгмийн амьдралд оролцуулах тааламжтай орчин бүрдүүлэх болон жендэрийн хандлагыг бэхжүүлэх талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

II. ТОДОРХОЙЛОЛТУУД

II.1 Хөгжлийн бэрхшээлийн тухай тодорхойлолт

Олон арван жилийн турш хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлсон загвартүгээмэл байсан бол одоо нийгмийн бүтэцтэй хамт авч үздэг болоод байна. Нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэдэг тодорхойлолт болон бусад тодорхойлолтод ажил хөдөлмөр эрхлэх чадваргүй байдал зэрэг эдийн засгийн загвар, хүмүүс өөрийн хөгжлийн бэрхшээлтэй байдалд сэтгэл зүйн талаас хандах зан суртахууны загвар зэрэг багтдаг.

Олон улсын байгууллагууд хүний эрхийн талаас нь илүү авч үзэж байгаа нь батлагдаж байна. 2006 оны 12-р сард НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн, адил тэгш эдлэх таашаалыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих”-ийг хүлээн зөвшөөрчээ. Энэ агуулгаараа уг конвенц хөгжлийн бэрхшээлийг дан ганц нийгмийн хамгааллын бус, хүний эрхийн болон хууль эрх зүйн асуудал гэж тодорхойлсон байна. Иймээс энэхүү баримт бичигт ялгаварлан гадуурхалтын эсрэг, адил тэгш боломж, идэвхитэй оролцооны арга хэмжээ зэрэг гол элементүүдийг багтаасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхүүд нь хөдөлмөр эрхлэлт, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бодлогын бүх салбаруудыг хамаарч байна.

II.2 НҮБ-ын Конвенцид ХБХ-ийг тодорхойлсон нь

НҮБ-ийн конвенцид ХБХ-ийг “Бие мах бодь, сэтгэл мэдрэл, оюун ухааны болон мэдрэхүйн согогтой, бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр бүтээлтэй оролцоход нь саад тотгор учирч буй хүмүүс” гэж тодорхойлсон байна.

II.3 Олон улсын түвшинд хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлийн ангилал (ДЭМБ)

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) - аас гаргасан “үйлдэл, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн дотоод ангилал”-д бие махбодын (физиологийн), сэтгэл зүйн үйлдэл болон биеийн бүтцийг хооронд нь тодорхой ялгаж заагласан байдаг. Уг ангилалд үйл ажиллагааны нөлөөлөл бүхий дараах 9 хүрээг дурьдсан байдаг. Үүнд:

- Сурах болон сурсан зүйлээ хэрэглэх
- Нийтлэг хэрэгцээ, шаардлага
- Харилцан мэдээлэл солилцох
- Бие махбодын үндсэн хөдөлгөөн
- Ахуй амьдрал
- Өөртөө тавих анхаарал халамж
- Хүмүүс хоорондын харилцан үйлчлэл болон харилцаа
- Амьдрах орчин
- Хөдөлмөр эрхлэлтийг оруулаад нийгэм, олон нийт, иргэний амьдрал

III. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖУУД НЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦИД ХЭРХЭН НИЙЦЭЖ БУЙ БАЙДАЛ

Монгол Улс Үндсэн хуулиндаа Монгол хүний үндсэн эрхийг хамгаалах, Монгол хүн бүр ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад адил тэгш эрхтэй байх зарчим болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд материалын хийгээд санхүүгийн тусламж үйлчилгээ хүртэх эрхтэй байхаар заасан байна.

ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци нь нэмэлт протоколуудын хамт НҮБ-ын 61-р Ерөнхий ассемблейгаар 2006 оны 12-р сарын 13-ны өдөр соёрхон батлагдсан билээ. Монгол Улс 2008 оны 12-р сард энэ конвенцид нэгдэн оржээ. Монгол Улсын Засгийн газар энэхүү чухал гэрээний зарчмуудыг бүрэн дүүрэн дэмжиж, ХБХ-ийн төлөө хийж буй үйл ажиллагаа хүчин чармайлтаа сайжруулахын тулд Конвенцид нэн даруй гарын үсэг зурсан байна.

Конвенцид нэгдсэний ач холбогдол нь арга барил, хандлагад гарсан “үзэл бодлын шинэчлэл” гэж хэлж болно. ХБХ-ийг зөвхөн буяны ажлын “объект” гэж үзэхээ больж, өөрсдийн эрхийг хэрэгжүүлэх, тэдний амьдралтай холбоотой шийдвэрийг чөлөөтэй, мэдээлэл, зөвшилцөл дээр суурилан гаргахыг шаардах эрхтэй бөгөөд чадвартай Монголын нийгмийн идэвхтэй гишүүн хувь хүнд тооцдог болов.

Энэ Конвенцид нэгдсэнээр Монгол Улс дараах үүргийг хүлээж байна:

- Энэ гэрээний дагуу тухайн улс орон нь эрх зүйн үүрэг хүлээх ба хэрэгжихүйц хууль тогтоомжийг батална;
- Конвенцийг соёрхон баталсан улс орнууд энэ талаар гарсан ахиц дэвшлийг Хороонд тогтмол тайлагнах;
- Улс орнууд ХБХ-ийн хүний эрхийг ялгаварлан гадуурхалтгүйгээр дэмжих арга хэмжээ авах;
- ХБХ-ийг ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, практикыг арилгах;
- Шинэ бодлого, хөтөлбөр батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бодолцож үздэг байх.

Монгол Улсын хууль тогтоомжууд нь ХБХ-ийн эрхийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ийн зөвлөмжийн дагуу тусгасан байна. Конвенцийн ихэнх хэсгийн хувьд Монгол Улсын хууль тогтоомжуудыг Конвенцийн мандатын түвшинд, эсвэл хэрэгжилтийг сайжруулах, нэмэлт арга хэмжээ авснаар уг түвшинд хүрэхүйц гэж тооцож болох байна. Энэ хэсэгт хууль эрх зүйн хамгаалалтын талаар ерөнхий шүүмжийг тодотгон харуулахын дээр одоогоор хэрэгжиж буй хууль тогтоомж, зохицуулалтыг чангатгахад тус болох зарим бодлогын санал дэвшүүлэв.

Конвенцид тавигдсан шаардлагуудыг биелүүлэхийн тулд 2007 онд долоон хуулинд ач холбогдол бүхий нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Түүнчлэн 2010, 2011 онуудад ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжтай холбоотой асуудлуудыг багтаасан хамгийн чухал хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна. Дараах Монгол Улсын хууль тогтоомжуудад ХБХ-ийн эрхийн тухай заалтууд байдаг. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хууль (2005 оны 12-р сарын 1)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль (2008 оны 1-р сарын 15)
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль (2008 оны 1-р сарын 15)
- Хөдөлмөрийн тухай хууль (1999 оны 5-р сар, хамгийн сүүлд 2008 оны 5-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2001 оны 4-р сарын 19, хамгийн сүүлд 2008 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан)

2010 оны 10 дугаар сарын байдлаар дараах хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулахаар хүлээгдэж байна:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Эдгээр хууль тогтоомжууд нь Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах нэгдсэн зорилготой юм.

Монгол Улсын хууль тогтоомж, бодлого болон ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хооронд дараах заалтуудын хувьд томоохон ялгаа байна гэж тодорхойлсны үндсэн дээр тэдгээрт анхаарлаа төвлөрүүлсэн болно:

9 дүгээр зүйл - Хүртээмж. Монгол Улсын хууль тогтоомжийн өнөөгийн хагас дутуу хэрэгжилт нь эрх зүйн шаардлага болон бодит байдлын хооронд зөрөө бий болгож байна.

19 дүгээр зүйл - Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх. Одоогийн Монгол Улсын хууль тогтоомж, бодлогод суурь өөрчлөлт шаардлагагүй боловч олон нийтийн дунд амьдрах эрхийг хязгаарлаж байна.

24 дүгээр зүйл - Боловсрол. Өнөөгийн Монгол Улсын Боловсролын тухай хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн тухай тусгайлсан заалт, эсвэл эдгээр хүүхдүүдийн чадавхийг хөгжүүлэхийг эрэлхийлсэн зүйл байхгүй байна.

27 дугаар зүйл - Ажил, хөдөлмөр эрхлэлт. Өнөөгийн Монгол Улсын хууль тогтоомжид мэргэжлийн сургалт, зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа, эсвэл тусгай ажлын байр зэрэг эрх тэгш байдлыг хангасан заалтууд байхгүй байна.

28 дугаар зүйл - Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал. Өнөөгийн Монгол Улсын хууль тогтоомж нь эдийн засгийн болон нийгмийн хамгааллыг хүний эрх гэж хүлээн зөвшөөрөөгүй байна.

Хүснэгт 1: ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхойлсон тодорхойлолтыг харьцуулах нь

No	НҮБ-ын Конвенц	ХБИ-ий Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын хууль	Өнөөгийн нөхцөл байдал
1	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог	Чадваргүй байх талаарх ойлголт нь ижил
2	Бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас	-----	Монгол Улсын хууль нь бусад төрлийн бэрхшээлийг ХБХ-ийн өмнө тулгарч буй асуудал гэж үзээгүй. Конвенцийн тодорхойлолт нь одоогийн бэрхшээлийг ирээдүйд тулгарах бэрхшээлийн эх үүсвэр гэж үздэг.
3	Бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох	Бусдын адил нийгмийн харилцаанд оролцох	Аль аль нь нийгмийн идэвхтэй хэсэг байх санааг тодотгосон

IV. ХБХ-ИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН ГОЛ ЗААЛТУУДЫГ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖТОЙ ХАРЬЦУУЛАН ХОЛБОГДОХ ЯАМДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сайн сайхан амьдрахад хамгийн чухалд тооцогдох асуудлууд, тухайлбал хүртээмж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх байдал, мэдээлэлд хүрэх боломж, боловсрол, эрүүл мэнд ба нөхөн сэргээлт, ажил, хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд дээр бид анхаарлаа төвлөрүүлээ.

IV.1 Хүртээмж

IV.1.1 Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжуудын харьцуулалт

Монгол Улсын Засгийн газар 9-р зүйлд тусгасан олон асуудлуудад чиглэсэн хууль тогтоомж, стандарт, зохицуулалтыг боловсруулсан байна.

Хүснэгт 2: Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар ХБХЭК ба Монгол Улсын хууль тогтоомжуудад хийсэн харьцуулалт:

НҮБ-ын Конвенц	Монгол Улсын хууль тогтоомж	Өнөөгийн нөхцөл байдал
<ul style="list-style-type: none"> - Бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох, - Хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, - Мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ, - Нийтэд нээлттэй үйлчлэх буюу үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих, - ХБХ-ийн өмнө тулгарч буй хүртээмжийн асуудлаар холбогдох талуудад сургалт зохион байгуулах - Барилга байшин, бусад байгууламжид Брайл үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх, - Хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчаар хангах 	<p>Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ Гуравдугаар бүлэг 9-р зүйл: Барилга, байгууламж нь ХБХ-ийн хэрэгцээг хангасан байна</p> <p>10-р зүйл: Барилгын зураг төсөл ХБХ-ийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгасан, Хот Байгуулалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт: Зүйл 20: ХБИ-д зориулсан дэд бүтцийг бий болгох</p> <p>20.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм, дүрэм, журамд заасныг баримтална.</p> <p>20.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтийн шийдэр, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно.</p> <p>Улсын стандарт: явган зорчигч, ХБИ-г зориулсан замыг төлөвлөх заавар, МК86056, Иргэний барилга байгууламжийг төлөвлөхдөө ХБИ-ийн орон зай, орчинг бодолцох, МК86055</p>	<p>Жишээ 1: АХБ- Хот төлөвлөлтийн төсөл</p> <ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомж, зохицуулалт байдаг - Хууль хэрэгжүүлэх бүтэц одоогоор байхгүй (барилга байгууламжид үнэлгээ өгөх комисст ХБХ-ийн төлөөлөл байх гэх мэт)

Эдгээр зүйлсийг барилга барих явцад шийдэхэд өртөг нь бага байна гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг бөгөөд барилгын хүртээмжийг хангахад нийт өртгийн нэг хувьд хүрэхгүй зардал нэмэгддэг байна.

IV.1.2 Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яаманд өгөх зөвлөмж

- Тээвэр, барилгын салбарт харилцан хамтран ажиллах замаар хэрэгжилтийг сайжруулах,
- Шийдвэр гаргах явцад, ялангуяа барилга байгууламж барих комисст ХБИ болон тусгай архитектор, инженерүүдийг хамт оруулдаг байх,
- Албан газар, зочид буудал, ресторан, зах, банк, эмнэлэг, сургууль, нийтийн үйлчилгээний барилгуудад налуу зам, бие засах газар, өргөн хаалга, барилгын орох хаалганд ойрхон газарт тусгайлан засч тэмдэг тавьсан машины зогсоол зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай тусгай тоноглол, төхөөрөмж суурилуулах талаар ухуулан сурталчлах. Хууль зөрчвөл торгууль төлдөг болгох,
- ХБХ-ийн бие дааж амьдрахыг дэмжсэн орон сууцны загвар боловсруулахад НҮБ-ын шилжин суурьшигчдийн асуудал эрхэлсэн дээд төлөөлөгчийн газар, НҮБ-ын амьдрах орчин байгууллага (UNCHS/НАВИТАТ) зэрэг олон улсын байгууллагын тусламж авах,
- НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБХХ, ЮНЕСКО, ОУХБ) болон ТББ-ууд нягт хамтран ажиллаж нийтлэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

Жишээ:

Хятадын Засгийн газар хотын зам, барилгын дизайны хууль батлах замаар ХБХ-ийн орчны хүртээмжийг сайжруулж, барилгын зураг төслийн сургалтын онолын хөтөлбөрт ХБХ саад бэрхшээлгүй зорчих орчны зураг төсөл ямар байх талаар хичээл оруулдаг болоод байна.

IV. 2. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө

IV. 2. 1 Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллээр хангагдах асуудлаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжид хийсэн харьцуулалт

21 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар ХБХ-т мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх үүрэг хүлээж байна.

Хүснэгт 3: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллээр хангагдах асуудлаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенци ба Монгол Улсын хууль тогтоомжид хийсэн харьцуулалт

НҮБ -ын Конвенц	Монгол Улсын хууль	Өнөөгийн нөхцөл байдал
<p>- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусадтай адилаар мэдээлэл, санал бодлоо хуваалцах, түгээх, хүлээж авах эрх</p> <p>- ХБХ-т зориулж мэдээлэл түгээхдээ хөгжлийн бэрхшээлийн төрөлд нь тохирсон хүртээмжтэй хэлбэр, технологиор хүргэх</p> <p>- Дохионы хэл, брайл үсэг, харилцааны нэмэлт болон сонголтот хэлбэр болон бусад хүртээмжит хэлбэрийг ашиглахыг хүлээн зөвшөөрөх, дэмжих</p> <p>- Нийгмийн бүх бүлэгт зориулсан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц, хүртээмжит хэлбэрээр (интернэтийг оролцуулан) түгээхийг уриалах</p> <p>- Интернэтээр мэдээлэл түгээдэг байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх</p> <p>- Дохионы хэлийг хэрэглэх явдлыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль:</p> <p>- "...16\ мэдээллийн найдвартай байдлын эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, яриа хэл, хэвлэн нийтлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх, жагсах, хуран цугларах дүрэм журмыг энэ хуулиар зохицуулдаг"</p> <p>- "17\ төрийн нууцад хамаарахаас бусад төрлийн мэдээллийг эрж хайх, хүлээж авах эрхтэй.</p> <p>- "ХБИ-ийг дэмжих үндэсний хөтөлбөр" ба "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр" нь 2006 оны 11-р сарын 19-ны өдрийн Засгийн газрын 283-р шийдвэрээр батлагдсан ба одоо хэрэгжиж байгаа.</p>	<p>- МҮОНТ-ийн нэвтрүүлгийн нийт цагийн 13.2% буюу өдөр тутам 2 цаг 10 минут дохионы хэл дээр нэвтрүүлэг цацагддаг.</p> <p>- Дохионы хэлний нэгдсэн тогтолцоо байдаггүй учраас ХБХ ойлгодоггүй (уг тогтолцоог 2007 онд нэвтрүүлсэн)</p> <p>- Сард 40 минутын нэвтрүүлгийг ХБХ-ийн холбоонд зориулж санал болгодог боловч энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүй.</p> <p>- Дохионы хэл, Брайл үсгийг албан ёсоор, олон нийтийн байгууллагууд ашигладаггүй</p> <p>- Ерөнхийдөө мэдээллийг хүртээмжтэй болгох оролдлого байгаа боловч Брайл үсгээр хэвлэгдсэн материал дутагдалтай байгаа нь хараагүй иргэдэд мэдээлэл хүргэх боломжийг хязгаарлаж байна.</p>

IV. 2. 2 НХХЯ-нд өгөх зөвлөмж

Гудамж талбай, олон нийтийн газрууд, амралт зугаалгын газар, нийтийн тээврийн хэрэгсэл, нийтийн орон сууц ашиглах зэрэг нийгмийн амьдралын бүх хүрээнд ХБИ-ийн эрхийг хуулиар хамгаалах ёстой.

- Хүний эрхийн асуудлууд, хөгжлийн бэрхшээлийн талаар дагнасан албан ёсны вэб хуудас ажиллуулах
- НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон олон улсын ТББ-уудаар дамжуулж үйлчилгээгээ хүргэх боломж хайх
- Нийтийн номын сангуудад харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж Брайл үсгийн болон аудио ном, материалын тусгай тасаг байгуулж, ажиллуулах
- Аймаг бүрт дохионы хэлний орчуулагч ажиллуулах
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл/радио, телевиз, сонин ашиглах:
 - Хөгжлийн бэрхшээл болон хүний эрхийн асуудал дээр дуугүй байдаг уламжлалыг эвдэж, үүнийгээ үндэсний стратеги болгох
 - Оролцооны арга, нөлөөллийн үнэ цэнэ, хандлагад дэвшилттэйгээр хандах
- Шинэ технологи ашиглах: вэбсайт, блог, чат, форум, интэрнэт дэх видео гэх мэт
- НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, үндэсний болон олон улсын ХБХ-ийн ТББ, холбоодтой интэрнэтийн сүлжээ байгуулж ажиллуулах.

IV. 3 Боловсрол

IV.3.1 ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Боловсролын тухай хуультай харьцуулах нь

Монгол Улсын Боловсролын тухай хуулиар сурч боловсрох үндсэн эрхийг баталгаажуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай сургуульд сургаж эхэлснээс хойш Монгол Улсын дотоодын хууль тогтоомж мэдэгдэхүйц сайжирсан. Монгол Улсын ХБХ-ийн нийгмийн хамгааллын тухай хуульд ХБХ-ийн сурах, боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх, соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ, нийгмийн үйлчилгээ хүртэх эрхийг тодорхойлсон байдаг. Тус хуулийн 7 дугаар зүйлд ХБХ-ийн сурах, боловсрол эзэмших эрхийн талаар:

- 1) Архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд ХБХ нь эрүүл иргэдтэй хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд бүх шатны боловсрол эзэмшихэд Төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 2) Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь ХБХ-ийг сургахаас татгалзах ёсгүй.

- 3) Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол авах эрхтэй.
- 4) Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуульд сурахад Төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж заажээ.

Гэхдээ Конвенцийн 24 дүээр зүйлд заасантай харшилдах зүйл байсаар байна. Одоогийн Боловсролын тухай хуульд Брайл үсэг ашиглах, дохионы хэл заах, дүлий иргэдийн хэл соёлын илэрхийлэмжийг дэмжих талаар тодорхой заалт, хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажилд авах талаар ямар нэгэн заалт байхгүй байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль зэрэг бүх түвшний боловсролыг хамарсан хуулиуд батлагджээ. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд жирийн сургуульд сурах тухай хууль байхгүй байна. Жонстоны (2002) тэмдэглэснээр Монголын багш нарын дунд онцгой хэрэгцээ шаардсан хүүхэд тусгай сургуульд сурах ёстой гэсэн ерөнхий ойлголт байдаг. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг цөөхөн сургууль байдаг ба тэд голдуу хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг л сургадаг бөгөөд эдгээр нь Улаанбаатар хотод байдаг.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулинд хүн бүр бүх салбарт адил тэгш эрхтэй байхыг заасан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн дунд, ахлах шатны боловсрол эзэмшихэд ялгаварлан гадуурхах ямар ч хууль, бодлого байхгүй” (Жонстон, ОУХБ, 2002). ХБХ-ийн Нийгмийн хамгааллын тухай хууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд асар их ач холбогдолтой хууль болсон. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP)-ын тайлбарласнаар уг хуулийн 7 дугаар зүйлд ХБХ-ийн сурч боловсрох, мэргэжлийн сургалтад хамрагдах эрхийг заасан байдаг. Энэ хуульд ХБХ архаг халдварт өвчингүй бол эрүүл иргэдтэй хамт (жирийн болон мэргэжлийн) сургуульд сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй болохыг заасан байдаг ч “Төр, олон нийт, эцэг эх, асран халамжлагч нь эдгээр хүүхдийн сургуульд сурах боломжийг дэмжинэ” гэж зааснаас өөр ямар нэг нэмэлт санхүүжилт, үйлчилгээний талаар дурьдаагүй байна (UNESCAP, 2003).

ХБХ-ийн хувьд бас нэг чухал хууль бол Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль юм. Энэ хуулинд ХБХ-т үзүүлдэг халамжийн үйлчилгээний талаар заасан байдаг. Эдгээрээс дурдвал: ХБХ-т өвлийн улиралд түлш өгөх, хол оршин суудаг ХБХ жил тутам эрүүл мэндийн үзлэгт хамрагдахад нэг талын унааны зардал олгох, ортопед аппаратын үнийг нөхөн олгох (амьдралынх нь туршид нэг удаа), дугуйтай сандал (16-аас доош насны хүүхдэд болон амьдралынх нь туршид нэг удаа), сонсголын аппаратын (эхний удаа үнэгүй, дараагийн удаа 50% хөнгөлөлттэй) үнийг нөхөн олгох, хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд сургуулиа төгссөний дараа орон нутагтаа буцах замын зардлыг нөхөн олгох, аймгийн төв орох унааны зардлыг нөхөн олгох, эмнэлэгт үзүүлэх зардлыг жилд нэг удаа 50% хөнгөлөх зэрэг орно (Зинамидэр, 2002).

Зарим холбогдох ном хэвлэлд үүнийг хангалттай бус гэж үзсэн байдаг. Жонстон (2002) судалгааныхаа дүгнэлтэнд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусдаа хууль гаргах шаардлагатайг онцолсон байдаг.

Брайл үсэг, дохионы хэлийг зааж сургах, сонсголын бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс багш бэлтгэх асуудал байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цэцэрлэг, бага сургуульд сурч хүмүүжихэд хүндрэлтэй байдаг. Тэдэнд зориулсан дэд бүтэц, мэргэжлийн багш, ажилтан, сургалтын материал байхгүй зэрэг нь орчин үеийн Монголын нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн иргэн болж бэлтгэгдэх боломжийг хязгаарлаж байна.

Бас нэг анхаарах ёстой чухал асуудал нь олон улсын хандивлагч, бизнесийн байгууллагуудын (жишээлбэл, Мянганы сорилтын сан, Рио Тинто, Айвенхоу Майнз зэрэг уул уурхайн компаниуд гэх мэт) тусламжтай хэрэгжүүлдэг Монгол Улсын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг хөгжүүлэх томоохон хөтөлбөрт ХБХ-ийг хамруулах төлөвлөгөө, чиглэл байхгүй байна.

Хүснэгт 4: ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Боловсролын тухай хуультай харьцуулах нь

Монгол Улс Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулиудаар боловсролын салбарыг удирдан зохицуулдаг. Бага дунд боловсролын тухай хуулинд ХБИ-ийн сурч боловсрохыг дэмжих тухай төрийн санхүүгийн дэмжлэг (36.8.7-р зүйл), сурч боловсрох боломжоор хангах (38.1.1-р зүйл), 17-оос доош насны хүн бүр сурах эрхтэй (39.1.3-р зүйл) зэрэг заалтууд байдаг.

Дээд боловсролын тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оройн болон эчнээ ангид сурах зэргээр сургалтын хэлбэрээ чөлөөтэй сонгохыг зөвшөөрдөг. 2002 оны 6-р сард Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг хэлэлцэн баталсан ба тус хуулийн 12.4, 11.2, 23.1-т ХБИ-ийн тухай авч үзсэн байдаг.

Оролцоог хангасан боловсрол, сургалтыг хөгжүүлэх гэдэг нь одоогийн уламжлалт заахаргыг шинэлэг аргатехникээр баяжуулах явдал юм. Оролцоог хангасан сургалтыг хөхиүлэн дэмжихийн гол ололт нь бүх нийтийг сурч боловсрох эрхээр хангах зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой. Мерси Кор ОУБ-ын саяхны судалгааны тайланд (Архангай, Өвөрхангай, Дундговь аймгийн ХБХ-ийн хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан, 2009) “ХБХ ядуурлын тойрогт оржээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох боломжгүй байдал, хөгжлийн бэрхшээлийн тухай сөрөг хандлагаас үүдэж боловсрол эзэмших боломжгүй болж, цаашид ажил хөдөлмөр эрхэлж чадахгүйд хүрч байна” гэжээ.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв

НҮБ -ын Конвенц	Монгол Улсын хууль	Өнөөгийн нөхцөл байдал
<p>ХБХ-ийн сурч боловсрох эрх:</p> <ul style="list-style-type: none"> • Бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгох, • Хувийн чанар, авьяас чадвар, бүтээлч чанарыг хөгжүүлэх, • Хувь хүний шаардлагад нийцсэн боломжийн орон байраар хангах, • Хувь хүнд чиглэсэн дэмжлэгийг үр дүнтэй хүргэх: • брайл үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтог арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг эзэмшүүлэх • дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы илэрхийлэмж, дохионы хэл сурахад туслалцаа үзүүлэх <p>ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 24-р зүйлд Оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг багтаасан бүх шатны болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог баталгаажуулна:</p> <ul style="list-style-type: none"> • ХБХ-ий хувийн онцлог шинж, авьяас чадвар, бүтээлч чанар ба тэдний оюуны болон бие махбодийн чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх • ХБХ-ийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох 	<ul style="list-style-type: none"> • Бага дунд, дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын тухай хуулиуд батлагдсан. Бага дунд боловсролын тухай хуульд ХБИ-ийн сурч боловсрохыг дэмжих тухай үндсэн заалт бий. • ХБИ-ий Нийгмийн хамгааллын тухай хуульд ХБИ-ийг сургалтын явцад тэгш эрхийг хангаж байдаг • 11.2-р зүйл сургалтын бүтцийн асуудлыг (анги, ажлын байр) багтаах. • 11.3-р зүйл өдөр, орой, экстернал, зайн сургалтын хэлбэрүүдээс ХБИ-д хамгийн тохиромжтой хэлбэрээр сургалт явуулах • 12.4-р зүйл ХБИ-ийг боловсрол, мэргэжлийн сургалтад хамруулах • 23.1-р зүйл нийгмийн түншлэлийн тухай “Нийгмийн түншлэл нь төр, ажил олгогчид, ажилтнууд, үйлдвэрчний холбоод, мэргэжлийн холбоод, үйлдвэр, албан байгууллага, олон нийтийн байгууллагуудыг багтаана. ...” гэж заажээ. 	<p>Жишээ 2: 113-р сургууль</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрлийг аль болох эрт, бага дээр нь тодорхойлох эрүүл мэндийн тусгай комисс байхгүй • Мэдээллийн технологи -программ зэрэг ХБХ-т зориулсан заах аргын тусгай материал байхгүй • ХБХ-т заах бэлтгэгдсэн мэргэжлийн багш, нийгмийн ажилтан, эмч байхгүй • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт муу <p>Жишээ 3: Улаанбаатар хот дахь Сэргээн засалтын үндэсний төв</p> <ul style="list-style-type: none"> • Эрэлт > Нийлүүлэлт • ХБХ-тэй ажиллах багш, сургагч нарыг их дээд сургуульд тусгайлан бэлтгэхгүй байна • Дэд бүтэц байхгүй • Сургалтын материал байхгүй • Эрүүл мэндийн төв, сургалтын төв хоёр тус тусдаа ажилладаг нэгжүүд бөгөөд эдгээрийн хооронд хамтын ажиллагаа байхгүй.

IV. 3. 2 БСШУЯ-нд хүргэх зөвлөмж

- 1) Боловсролд хуваарилдаг нийт төсвийг нэмэх, улмаар ХБХ-ийн боловсролд зарцуулах төсвийг нэмэх.
- 2) “Уламжлалт” багш нарт хөгжлийн бэрхшээлийн талаар илүү сайн мэдээлэл түгээх зорилгоор их дээд сургуулийн түвшинд давтан курс зохион байгуулах. Энэ нь боловсролын байгууллагад ажиллаж буй хүмүүсийг (мэргэжилтэн болон бусад) сургах мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг бий болгох зорилготой юм. Гэвч, багш нар сурч, мэдсэн ур чадвараа өөрсдийн зааж буй хичээлдээ үр дүнтэй ашиглах чадвар эзэмших нь хамгийн хүнд асуудал байдаг.
- 3) Багш нар шинэ арга барил, заах аргыг (мэдлэг олгох төрөл бүрийн программ) хэрхэн ашиглах, тэдгээрийг ангийн болон сургуулийн үйл ажиллагаанд хэрхэн нийцүүлэх талаар сургалтад хамрагдах шаардлагатай.
- 4) Асуулт хариулт, хэлэлцүүлгийн арга, урлаг, уран сайхны, бүлгээр ажиллах арга, үе тэнгийнхний дунд тодорхой ажил зохион байгуулах зэрэг сэтгэл зүй, бие, оюун санааны хөгжил, нийгмийн амьдралд оролцоход нь нөлөөлж болох янз бүрийн арга ашиглах.
- 5) Сургуулиуд ХБХ-ийг сургахад үзүүлэх эдийн засгийн урамшуулал бий болгох.
- 6) ХБХ-т тохирсон заах арга боловсруулах, судалгаа шинжилгээний ажилд оролцож буй багш нарт дэмжлэг үзүүлэх.
- 7) Дохионы хэл, Брайл үсэгт мэргэшсэн болон хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажилд авах.
- 8) ХБХ-тэй ажиллаж буй багш, сургагч нарт (ялангуяа алслагдсан бүсэд) илүү цалин олгох, ажлын цагийг багасгах.
- 9) ХБХ-д зориулсан зайн сургалтын хөтөлбөр бий болгох.
- 10) Брайл үсэг, аудио ном зэрэг сургалтын материалтай болох.
- 11) Дохионы хэлний багш/орчуулагчдыг бэлтгэх.
- 12) Ингэхдээ насанд хүрсэн дүлий иргэдээр оюутнуудад хичээл заалгах.
- 13) Дүлий хүүхдүүдэд хичээлийн материалын бичмэл хувийг өгч байх.
- 14) ЮНЕСКО-ийн Бүх нийтийн боловсролын тайланд зааснаар сургууль бүрт 1-2 багшийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан ажилтнаар бэлтгэн, тэдэнд зориулсан сургалт зохион байгуулах.
- 15) Сайн туршлагыг бусад багш нарт түгээн дэлгэрүүлэх.
- 16) Явуулын багш, сургагч нарыг бэлтгэх.
- 17) Багш нарт зориулсан заавар зөвлөмж, гарын авлага бэлтгэх.
- 18) Бакалавр, магистрын сургууль төгсөгчдийг ХБХ-т багшлах арга барилд суралцуулах, дадлага хийлгэх.
- 19) Хүүхдийн эмч, сэтгэл судлал, сэтгэл зүй, хүүхдийн сэтгэл судлал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сувилал болон сэтгэл зүйн эмчилгээ

зэрэг мэргэжлээр Монголд их дээд сургууль төгссөн оюутнуудад зориулан зуны тэтгэлэгт хөтөлбөр боловсруулах.

- 20) Тусгай боловсролын хэрэгцээ, ХБХ-ийг сургалтад хамруулах талаар гарсан шилдэг туршлагауудын эмхтгэл гаргах.
- 21) Уламжлалт ажил хөдөлмөрөөс гадна орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээнд (электроник, и-бизнес, дуудлагын төвүүд гэх мэт) тохирох ХБХ-ийг бэлтгэхэд анхаарах.
- 22) Анхааруулах тэмдгүүдийн (анхаарал муу/зохисгүй хариулт, хэл ярианы хөгжил муу, заавар зөвлөмж дагахад бэрхшээлтэй, бусадтай ойлголцоходоо хүндрэлтэй зэрэг) талаар сургалт явуулах.
- 23) Сэтгэл зүй, Сурган, Эрүүл мэнд, Сургалтын (СЗСЭМС) төвийг аймаг бүрт байгуулан ажиллуулах.

Хөгжлийн бэрхшээлийн талаар өмнө нь ямар асуудал тулгарсан, амьдралд хэрхэн хөлөө олох гэж хичээж байгаа талаар хүүхэд багш нар хамтдаа ярилцах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчидтэй ажиллаж байгаа багш нар гэмтэл согог хүүхдэд хэрхэн нөлөөлдгийг ойлгох, илүү онцгой анхаарал шаардаж буй хүүхдүүдийг илрүүлэх, таньж мэдэх, тэдний сурах хэрэгцээнд ангиа хэрхэн тохируулах зэрэгт суралцах ёстой. 1984 онд Гармези, Мастен ба Теллеген нар “стресст орсноос бусад үед хүүхдийн үзүүлэх чадвар” нь тэдний хатуужлийг илтгэнэ гэжээ.

1994 онд Мастен хатуужлыг тодорхойлохдоо, “хувь хүний хатуужил гэдэг нь эрсдэл, хүнд хэцүү байдлыг үл харгалзан аливаа зүйлд амжилттайгаар дасан зохицох чадварыг хэлнэ” гэжээ. Цаг хугацаа өнгөрөх бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд/насанд хүрэгчид түүндээ амжилттайгаар дасан зохицох болно. Үүний тулд эдгээр хүүхэд/насанд хүрэгчдэд асар их биологийн, сэтгэл зүйн, байгаль орчны нөөц баялаг хэрэгтэй. ХБХ-т (хүүхэд, насанд хүрэгчдэд) зөвхөн эцэг эхийн төдийгүй боловсролын салбарын ажилтнууд болон бусад хүмүүсийн энэрэл хайр, халамж дэмжлэг хэрэгтэй байдаг.

Сургалтын хөтөлбөрт (аймаг бүрт явуулах) дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг оруулахыг санал болгож байна:

- Хүүхэд, багш нарт нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хямарсан хүүхдийн сэтгэл зүй, бие, оюун санааны хөгжил, нийгмийн амьдралд оролцоход нь нөлөөлж болох төрөл бүрийн арга, техник (асуулт хариултын арга, хэлэлцүүлэг хийх, урлаг уран сайхны арга, бүлгийн ажил болон үе тэнгийнхний дунд зохиох ажил) ашиглах;
- ХБХ-ийн хоорондын харилцаа, холбоо;
- Гэр бүлийнхний хоорондын харилцаа, холбоо;
- Сэтгэл зүйч, нийгмийн сурган хүмүүжүүлэгч болон эмнэлэг, эрүүл мэндийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдтэй харилцан ярилцах;
- Хатуужлын (амжилтын) түүх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийн учир шалтгаан, тэдний зан байдал, иргэншил зэрэг хувь хүний онцлогт тохирсон сургалтын төлөвлөгөөг тэдний ур чадварт суурилан боловсруулах шаардлагатай. Үүнийг шинэ хандлага, арга барил, үнэ цэнэ зэргийг анхаарч тусгайлан бэлтгэгдсэн багш, эмч, сувилагч болон нийгмийн ажилтнуудын хамт хэрэгжүүлбэл хамгийн үр дүнтэй болно.

- ХБХ-т сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, урамшуулах, өгүүлбэр давтан хэлүүлэх, чанга тод яриулах зэрэг заах аргын стратегийг ХБХ-тэй ажиллаж буй хүмүүст зааж сургах,
- БСШУЯ тусгай анхаарал шаардсан хүүхэд, оюутнуудад туслах, орлох багш нараар хангах ёстой. Франц, Герман, Англи зэрэг орнуудад ийм төрлийн дэмжлэг үзүүлж, амжилтанд хүрээд байна. Ийм багш нар зөвхөн нэг бус хэд хэдэн сургуульд ажиллах чадвартай байдаг.
- НХХЯ, ЭМЯ-тай хамтран дараах асуудлуудыг санхүүгийн хувьд шийдэх:
 - ХБХ-т багшлах арга барилын талаар бакалавр, магистрын сургууль төгсөгчдийг дадлага ажил хийлгэх.
 - Хүүхдийн эмч, сэтгэл судлал, сэтгэл зүй, хүүхдийн сэтгэл судлал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сувилал болон сэтгэл зүйн эмчилгээ зэрэг мэргэжлээр Монголд их дээд сургууль төгссөн оюутнуудыг зуны сургалтын хөтөлбөрт хамруулах
 - Их дээд сургууль төгссөн оюутнуудад дээр дурьдсан мэргэжлээр цаашид суралцахад нь тэтгэлэг олгох
 - Хөгжлийн бэрхшээл, ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлт сэдвээр хамтарсан судалгааны ажил хийх докторын, докторын дараах сургалтын хоёр орны солилцооны хөтөлбөрт хамруулах

Жишээ:

- Афганистанд сонгогдсон 29 сургуулийн хичээлийн эрхлэгч нарт зориулсан оролцоог хангасан сургалтын талаар семинар зохион байгуулжээ (ЮНЕСКО, Кабул, 2010).
- ЮНЕСКО-ийн оролцоог хангасан сургалтын үнэлгээний тайланд зөвлөсөн зөвлөмжийн дагуу Арменд онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг эрт илрүүлэх төв байгуулжээ. Одоогийн байдлаар 11 аймгийн 49 сургуульд оролцоог хангасан сургалтын загвар бий болгоод байна.
- Бангладеш, Пакистан, Лаос зэрэг улсууд суурь боловсролд албан бусаар хамрагдах байдлыг сайжруулах шинэлэг аргыг нэвтрүүлэхээр үндэсний хөтөлбөр боловсруулж байна.
- Кени, Танзани зэрэг орны сургууль, иргэдэд түшиглэсэн нөхөн сэргээлтийн хөтөлбөрүүдтэй хэрхэн холбогдох, явуулын багш нарыг сургах талаар онцгой анхаарч байна (Сюзэн Питерс, оролцоог хангасан сургалтын 2004 оны тайлан).

IV. 4. Эрүүл мэнд, нөхөн сэргээлт

IV. 4. 1 ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Эрүүл мэнд, нөхөн сэргээлтийн тухай хуультай харьцуулах нь

Монгол Улсын иргэдийн эрүүл мэндийн тусламж, эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн ихэнх хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг. Харамсалтай нь энэ сангаас эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг бүрэн гаргадаггүй бөгөөд үйлчилгээний төлбөрийн тодорхой хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө төлөх хэрэгтэй болдог. Монгол Улсад ХБХ-ийн 70% нь ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдардаг (ХБИ-ийн ТББ-ын үндэсний холбоо 2009). Тиймээс, ХБХ-т үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нь эн тэргүүнд хийх ажлуудын нэг юм. Одоогийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хуулийн эрүүл мэндийн талаар заалтууд нь ХБХ-т сайн үйлчлэхгүй байна гэсэн шүүмж их байдаг. Асуудлын гол нь хувь хүний бие даасан байдал, хөдөлмөрийн хүчний оролцоонд шаардлагатай тусламж, туслалцаа болон тусламжийн зүйлсийн технологи зэрэг ихэнх үйлчилгээ нь “эмнэлгийн” үйлчилгээнд тооцогддоггүй бөгөөд эрүүл мэндийн даатгалаас энэ төрлийн үйлчилгээнд мөнгө олгодоггүй байна. Эрүүл мэндийн даатгал нь ихэнхдээ хөгжлийн бэрхшээлийн нөхөн олголтонд хатуу хязгаарлалт тавьдаг (21, түүнээс дээш өдөр нөхөн сэргээлт хийлгэхэд зөвхөн 10 хоногийн мөнгийг л төлдөг жишээтэй) байна. Түүнчлэн нөхөн сэргээлтийн зардлыг эрүүл мэндийн даатгалаас бүрэн төлдөггүй, зөвхөн 50%-ийг л гаргадаг. Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас онцгой нөхцөлд жил бүр эсвэл насан туршид нь олгох зөвшөөрөгдсөн дүнг тогтоодог (энэ нь шаардлагатай дүнгээс хэд дахин бага байх жишээтэй).

ХБХ-ийн эрүүл мэндтэй холбоотой гол дутагдалтай асуудал нь урт хугацааны асаргаа, халамж үзүүлэхийн оронд мөн заавал “анагаах ухааны хувьд зайлшгүй” ноцтой хүнд өвчин байх ёстой гэсэн эмчилгээний шаардлага нь ихэнхдээ эмнэлгийн тоног төхөөрөмж, туслах технологийг оруулдаггүй.

Нийгмийн халамж, нийгмийн хамгааллын тэтгэмж нь ХБХ-ийг ажил хийхэд урамшуулахад чиглэгддэг. Жишээлбэл, ажилгүй ХБХ сар бүр нийгмийн халамжид 53800 төгрөг авч байхад таваас дээш жил ажилласан хүн нийгмийн халамжийн сангаас 105000 төгрөг авдаг. ХБХ ажил эрхэлбэл нийгмийн халамжийн сангаас тэтгэмж авахаас гадна ажлын хөлс доод тал нь 150000 төгрөгийн цалин авдаг (Хараагүй хүмүүсийн сургалт, үйлдвэрийн газрын захирал З.Болдсайхан, 2010).

Хүснэгт 5: ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын Эрүүл мэнд, нөхөн сэргээлтийн тухай хуультай харьцуулах нь

НҮБ -ын Конвенц	Монгол Улсын хууль	Өнөөгийн нөхцөл байдал
<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, • Эрт оношлох, эмчлэх, • Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан үйлчилгээг бүх газарт тухайлбал хөдөө орон нутагт аль болох гэрт нь ойр газар үзүүлэх, • Эмч эмнэлгийн ажилтнууд ХБХ-т бусдад үзүүлдэгийн нэгэн адил чанартай үйлчилгээ үзүүлнэ. 	<p>Монгол Улсын Үндсэн хууль, 16-р Зүйл: Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно. <p>Эрүүл мэндийн тухай хууль</p> <ul style="list-style-type: none"> • 28-р Зүйл: Эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрх • 12-р Зүйл: Эм тарианы зардлын тодорхой хэсгийг төр хариуцна 	<p>Жишээ 4: Төв аймгийн Өндөрдов дахь ХБИ-ийн Нөхөн сэргээх төв.</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн сэтгэлзүйч, нөхөн сэргээх эмчилгээний ажилтнууд нь хангалттай бус, • Материал тоног, төхөөрөмж дутагдалтай, • Эрүүл мэндийн даатгал нь нөхөн сэргээх эмчилгээний зардлын зөвхөн 30%-г л төлдөг, • Нөхөн сэргээлтийг аль болох эрт үед нь эхлэх, • Нийгэмд оролцох оролцоог нь дэмжих, • Нөхөн сэргээлт, нөхөн сэргээх үйлчилгээний ажилтнууд, мэргэжилтнүүдийг сургах. <p>Жишээ 5: 113-р сургууль ба Нөхөн сэргээх төв</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх ажлыг зохистой хийгээгүй • Дэд бүтэц хангалтгүй • Материал, тоног төхөөрөмж дутагдалтай • Эдийн засгийн болон хүний нөөц хангалтгүй • Заах арга барил хангалтгүй <p>Жишээ 6: ТББ-уудтай хийсэн бүлгийн уулзалт ярилцлагаас</p> <ul style="list-style-type: none"> • Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлд мэргэшсэн, зөв оношлох чадвартай эмч нар дутагдалтай (ТББ-ын удирдлагуудтай хийсэн бүлгийн уулзалт ярилцлагаас)

IV. 4. 2 Эрүүл мэндийн яаманд хүргэх зөвлөмж

- 1) Төрөхийн өмнө болон нярай үед нь оношилж, хөгжлийн бэрхшээлээс аль болох эрт урьдчилан сэргийлэх (цусны шинжилгээ, эхограф, амниосинтез гэх мэт...).
- 2) Сургуулийн хүүхдүүдийг албан сургалтын эхний жилд (5-6 насанд) нь дараах зорилгоор эмнэлгийн үзлэгт заавал хамруулах:
 - Хожим нь хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалыг тодорхойлох,
 - Хөгжлийн бэрхшээлийн түвшин, зэргийг тодорхойлох (хэрвээ боломжтой бол),
 - Суралцах явцад хөгжлийн бэрхшээлийн бодит байдалдаа дасан зохицох эсвэл сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах
- 3) Хүүхдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, тэднийг осол эндэгдэлд орох эрсдлийг багасгахын тулд үндэсний компанит ажил зохион байгуулах
- 4) Жирэмсэний үед дараах хэрэглээнээс үүдэлтэй эрсдэлийн талаар эмэгтэйчүүдэд мэдээлэх зорилгоор ТВ компанит ажил зохиох:
 - Хууль бус мансууруулах бодис: героин, кокаин, марихуан, амфетамин
 - Хуулиар хориглоогүй бодис: архи, тамхи, бусад зүй бус эм тариа.
 - Жирэмслэлтийн эхний гурван сард нялх хүүхдийн бие эрхтэн, махбодь, тогтолцоо нь бүрэлддэг. Энэ үед хэрэглэсэн зарим мансууруулах бодис хэзээ ч эдгэрэхээргүй, ноцтой эмгэг үүсгэх үр нөлөөтэй.
- 5) Ялангуяа 35-аас дээш насны болон жирэмсэн бүх эхчүүдэд шаардлагатай эрт оношлогооны хэрэгслийг ашиглах.
- 6) Амьдарч байгаа газраас нь хол байсан ч ХБХ-ийг Монгол орны нутаг дэвсгэр дээр эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд үнэгүй хамруулах
- 7) Эрүүл мэндийн болон боловсрол/сургалтын салбарыг хослуулсан орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн ХБХ-ийн ур чадвар, хандлагыг дэмжин урамшуулсан Сэтгэл зүйн, сурган хүмүүжүүлэхүйн, эрүүл мэндийн болон сургалтын төвийг (ССЭСТ) хөгжүүлэх үр дүнтэй, тодорхой арга хэмжээг авах.
- 8) Хүүхдийн эмнэл зүй, сэтгэл зүй, хүүхдийн сэтгэц судлал, ХБХ-ийн сувилагч, аудиолог, хөдөлмөрийн нөхцөл судлаач зэргийг Их сургуулийн болон эмнэлгийн түвшинд бэлтгэх.
- 9) Хөгжлийн бэрхшээлийн эрүүл мэнд, нөхөн сэргээлтийн талаарх сайн туршлага, жишээг багтаасан ном товхимол бэлтгэх.

Жишээ:

Чили улс сургуулийн ажилтнуудыг хамруулсан бага насны хүүхдийн боловсролд оролцоог хангасан сургалтын арга боловсруулжээ.

IV. 5 Ажил, хөдөлмөр эрхлэлт

IV. 5. 1 Хөдөлмөр эрхлэлтийн асуудлын талаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын дотоодын хууль тогтоомжтой харьцуулах нь:

НҮБ-аас 1948 оны 12-р сарын 10-нд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хүн бүр ажил хөдөлмөр эрхлэх, ажилгүйдлийн эсрэг хамгаалуулах эрхтэй” гэжээ.

НҮБ-аас 2006 оны 12-р сарын 13-нд баталсан ХБХ-ийн эрхийн тухай конвенцид ХБХ бусадтай адил тэгш үндсэн дээр ажил хөдөлмөр эрхлэх эрхтэй байна гэж заажээ.

ХБХ-ийн нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын хуулийн 9-р зүйлд ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар:

- ХБХ-ийг ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- ХБХ-ийн эрхэлж буй бизнес, үйлчилгээг төр дэмжинэ.
- ХБХ-ийг ажиллуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлт эдлүүлнэ.
- Аж ахуйн нэгжүүд ХБХ-ийг тохиромжтой ажлын байраар хангах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар болон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын тодорхойлсон хөгжлийн бэрхшээлийн түвшин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлаж байна гэж үздэгээ хөгжлийн бэрхшээлийн асуудалд оролцогч талууд (Засгийн газрын ажилтнууд, ТББ-ын удирдагчид) илэрхийлсэн. ТББ-уудын төлөөллийн үзэж байгаагаар уг комиссын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн түвшинг тогтоох аргачлал нь буруу юм. Хүн хөгжлийн бэрхшээлтэй байж болох ч ажиллах хүсэл зорилго, чадвартай байж болно. Гэвч энэ хорооны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүн нь мөн ажиллах чадвараа “алдсан” буюу хөгжлийн бэрхшээлийн түвшин (50%, 70%, 100%) нь хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувьтай яг адилхан байна (50%, 70%, 100%) гэсэн үг. Харин энэ нь бодит байдалтай нийцэхгүй байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд “биемахбодийн буюу сэтгэл санааны хөгжлийн бэрхшээл” ба “хөдөлмөрлөх чадвар” гэсэн хоёр өөр ойлголтыг хооронд нь салгаж тодорхойлох хэрэгтэй.

Ялгаварлан гадуурхалтын эсрэг үзэл баримтлалын үүднээс авч үзвэл Монгол Улсын хууль тогтоомж болон ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хооронд ялгаа их бөгөөд ХБХ-ийн эрхийн тухай конвенци нь ажилд орохын өмнөх сургалт мөн мэргэжлийн нөхөн сэргээлтэнд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлахыг хориглодог. Хамгийн гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөр эрхлэх шилжилтийн үйл явцад олон нийт тусламж, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй (бусад орны туршлагаас

үзэхэд нийгмийн зүгээс үзүүлэх тусламж туслалцаа нь наад зах нь 6 сар үргэлжилбэл зохино). Хэдийгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхахыг хориглодог ч хөгжлийн бэрхшээлтэй Монголчуудын хувьд ямар арга замаар ажил олох талаарх заалт дутагдалтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй Монгол хүний ажилгүйдлийн түвшин хэт өндөр байгаа нь үүнийг нотолно. ХБИ дотроос нийгэмд хамгийн их гадуурхагддаг, давхар ялгаварлан гадуурхалтад өртдөг хүмүүс (тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгшчүүд) нь оюуны болон сэтгэцийн өвчтэй хүмүүс ба тэдний хувьд асуудал илүү хүнд байдаг.

Хүснэгт 6: Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг Монгол Улсын дотоодын хууль тогтоомжтой харьцуулах нь:

НҮБ -ын Конвенц	Монгол Улсын хууль	Өнөөгийн нөхцөл байдал
<ul style="list-style-type: none"> • Бусадтай адил тэгш хөдөлмөр эрхлэх эрх; • Ялгаварлан гадуурхалтыг хориглох (ажилд авах нөхцөл, хөлсөөр ажиллуулах, ажил олгох, хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах); • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах (адил хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах) • Бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай холбогдох эрхээр хангагдах; • Техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажлын дадал олгох, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтад үр дүнтэй хамрагдах • Хөдөлмөрийн зах зээлд ажил хийх болон мэргэжлийн хувьд дэвших боломжийг дэмжих <ul style="list-style-type: none"> • Ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж ороход нь туслах; • Хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих; • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах; • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангах; 	<p>Монгол Улсын Үндсэн хуульд Хөдөлмөр эрхлэх эрхийн талаар:</p> <ul style="list-style-type: none"> • Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах... эрхтэй гэж заасан байдаг. <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-111.7-р Зүйлүүд</p> <ul style="list-style-type: none"> • ХБИ-ийг ажиллуулж буй ажил олгогчийг дэмжих Хөдөлмөрийн хуулинд оруулах нэмэлт өөрчлөлт (нэмэлт 3 догол мөр) <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, 12.1-12.3-р Зүйлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • ХБИ-д зориулсан сургалтын төвд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ХБИ-ийг ажилд нь бэлдэх, ажил олгогчдыг сонгож өгөх <p>Орлогын албан татварын тухай хууль:</p> <ul style="list-style-type: none"> • хараагүй хүмүүсийг ажилд авсан тохиолдолд орлогын албан татвараас чөлөөлнө 	<ul style="list-style-type: none"> • Сайн хууль тогтоомж, дүрэм журамтай, гэвч хэрэгжилт нь муу байна • Бусад орнууд НҮБ-ын конвенцид нийцүүлэхийн тулд өөрсдийн хууль тогтоомж, дүрэм журмаа сайжруулдаг талаар шилдэг туршлагаас суралцах <p>Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлтийн тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үнэлгээгээр тогтоосон хөгжлийн бэрхшээл нь хөдөлмөр эрхлэх чадвараа алдсан гэсэн ойлголт биш. <p>Жишээ 7: Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр</p> <ul style="list-style-type: none"> • Өдөрт 8 биш 6 цаг ажилладаг, • ХБХ-ийн онцлогт тохирсон дэд бүтэц хангалтгүй байна, • ХБХ-д зориулсан тоног, төхөөрөмж, материал хангалтгүй, • ХБХ-ийн ажлын байрыг “хар ажил” гэж ойлгож ирсэн, • Орчин үеийн зах зээлд нийцсэн шинэ ажлын байр бий болгох боломж бололцоог хайх шаардлагатай, • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс авсан судалгаагаар ХБХ-ийн 57% нь ажлын нөхцөл нь тэдэнд тохирсон гэж үздэггүй, • 2633 аж ахуйн нэгжүүд 8954 ХБХ-д ажил олгох боломжтой. ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийх, Хөдөлмөрийн тухай хуулийг ашиглах хэрэгтэй. <p>Жишээ 8. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр, ТББ-тай хийсэн бүлгийн ярилцлага</p> <ul style="list-style-type: none"> • Зохистой дэд бүтэц хангалтгүй • Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн дутагдалтай • Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн сургалт хомс • Үйлдвэрийг яаралтай шинэчлэн босгох шаардлагатай

IV. 5. 2 Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргэх зөвлөмж

- Ажил олгогчдыг хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн талаар болон Монгол Улсад ХБИ-ийг ажиллуулах тухай хуулийн мэдээллээр сайн хангах
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р Зүйл “25, түүнээс дээш ажилтантай ажахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэсэн заалтын дагуу ХБИ-ийг ажилд авахгүй байгаа ажил олгогчдод авах арга хэмжээг чангатгах. Уг заалтыг биелүүлээгүй тохиолдолд торгууль төлүүлэх, дахин давтал торгуулийн хэмжээг нэмэх, гурав дахь удаагаа давтал бизнесийн үйл ажиллагааг нь хаах.
- Нөгөө талаар ХБХ-ийн хэрэгцээнд зориулж ажлын байраа засч тохижуулсан ажил олгогчдод санхүүгийн урамшуулал үзүүлэх
- Ажилд олгогч ХБХ-ийг ажилд авахдаа хөгжлийн бэрхшээлтэй эсэх, түүний зэргийн талаар асуухгүй байх

Жишээ:

- АНУ-ын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийн тухай баримт бичигт “ажил хөдөлмөр эрхлэх эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй аливаа хувь хүн ялгаварлан гадуурхалтын эсрэг шүүхэд хандаж болно. Түүнчлэн хувь хүн, албан байгууллага бусад хүнийг хамгаалах зорилгоор шүүхэд хандаж болно” гэжээ. Мөн тус баримт бичигт 2008 оны Генетик мэдээллээр үл ялгаварлах хуулийн 11-т “генетик мэдээллийг үндэслэн өргөдөл гаргагч, ажиллагсад, өмнө нь ажиллаж байсан ажиллагсдыг ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж заасан байдаг.
- АНУ болон Канадын хөдөлмөрийн холбоод Засгийн газар, ажил олгогчидтой хамтарч Үйлдвэрийн төсөл хөтөлбөрөөр дамжуулан ХБХ-ийг хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлж, эргээд хөдөлмөрийн холбоодын нөөцийг Засгийн газрын санхүүжилт, ажлын байр бий болгох болон сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд ашигладаг.

IV. 6 Хуулийн хэрэгжилт, мониторингийн талаар өгөх зөвлөмж

Улаанбаатар хотод ажиллах хугацаандаа бид ХБИ-ийн эрхийг хамгаалах өнөөгийн хууль тогтоомж, зохицуулалтын хэрэгжилтийн механизмийг сайжруулах шаардлагатай буюу одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилт хангалтгүй байдгийг олж мэдлээ. Хуулийн хэрэгжилтийг сайжруулснаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээл, түүнтэй холбоотой эрх зүйн, бодлогын төлөвлөлтийн, бүтэцийн зэрэг асуудлуудыг ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид заасан эрхийг өргөн хүрээнд хамгаалахад тустай байх юм. Түүнчлэн хэрвээ Монгол Улс ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг соёрхон баталсан эхний хэдэн нэгдэгч Улс орнуудын нэг байсан бол өнөөгийн хууль журмын хэрэгжилтэд бас анхаарал хандуулсан байх ёстой байв.

ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 33-40-р Зүйлүүдэд заасан хэрэгжилтийн дагуу уг конвенцод нэгдсэн Улс орнууд нь Засгийн газар дотроо Конвенцийн хэрэгжилттэй (33-р Зүйл) холбоотойгоор нэг буюу түүнээс дээш хариуцсан нэгж байгуулах улмаар гэрээний биелэлтийн талаар тайлан явуулах (35-р Зүйл). Эдгээр нь одоогоор Монголд байхгүй (ХБХ-ийн асуудлыг цогцоор нь хариуцсан агентлаг байхгүй байгаа) боловч одоогийн бүтцийн хүрээнд ямар агентлаг хөгжлийн бэрхшээлтэй холбоотой ямар асуудлыг хариуцдаг болохыг үнэлэх нь чухал.

Жишээ:

Бэркли дахь Калифорнийн их сургуулийн Боалт Хол хуулийн сургууль Хөгжлийн бэрхшээлийн дэлхийн институттэй хамтран хууль тогтоомж, зохицуулалтын хэрэгжилтийг үр дүнтэй болгохын тулд олон улсын норм стандартыг цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, судалгаа зэргийг тодорхойлох зорилгоор хөгжлийн бэрхшээлийн бодлого, хуулийн чиглэлээр ажилладаг олон улсын экспертүүдийн уулзалт зохион байгуулжээ. Энэ уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй холбоотой олон улсын норм стандартын тухай авч хэлэлцсэн байна (1998 оны 12-р сарын 8-12, Бэркли).

Хууль эрх зүй, зохицуулалтын хэрэгжилтийг хариуцсан институци бий болгох (ХБИ-ийн эрхийн төлөө агентлаг)

ХБИ-ийн эрхийг хамгаалах төрөлжсөн агентлагийг хөгжлийн бэрхшээлийн хууль, бодлогын хэрэгжилтийг сайжруулахын тулд байгуулах хэрэгтэй. Эрх зүйн хэрэгжилт, хяналтын үүрэг хариуцлагыг биелүүлэх Агентлаг нь дараах газруудаас бүрдэх нь зүйтэй:

- ◆ **Эрх тэгш хөдөлмөр эрхлэх боломж олгох газар**
- ◆ **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн газар** (Хууль зүй дотоод хэргийн яаман дээрх хуучнаар Иргэний эрхийн газар). Тус газар нь хууль зөрчсөн тохиолдол бүрт шүүхэд нэхэмжлэл гаргах үүрэгтэй байх багтах ёстой:
 - Төрийн ажил олгогчдын эсрэг шүүх ажиллагаа
 - Зохистой хэм хэмжээнд нийцсэн төрийн болон орон нутгийн барилга байшингийн кодын гэрчилгээ

Жишээ:

Аргентинд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлийн асуудлыг зохицуулах сайжруулах тусгай хороо байгуулжээ.

- ◆ **Орон байр ба иргэний хуулийн хэрэгжилтийн газар**

Энэ газар нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэд бүтцийн хэм хэмжээг харгалзаж үзэх ба барилгын компаниуд болон бусад оролцогч талууд хууль эрх зүй, дүрэм журам, хэм хэмжээг биелүүлээгүй бол эрх зүйн гомдол гаргаж, арга хэмжээ авч болно.

◆ **Зам тээврийн газар**

Зам тээврийн газар нь ХБХ-т зориулсан зам тээврийн заалт, хэм хэмжээний талаар заасан зохицуулалтыг сайжруулах үүрэг хариуцлага хүлээнэ. Энэхүү газар нь олон нийтийн тээвэр, замын хөдөлгөөн, хот буюу аймаг хоорондын зам тээвэр гэх мэт зам тээвэртэй холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх эрх зүйн зүйл заалтыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээх юм.

◆ **Боловсролын газар**

Энэ газар нь бага дунд сургуулийн боловсролын тогтолцоо, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллага (анагаах ухаан, шүдний, сувилахуйн ухааны болон бусад эрүүл мэндийн чиглэлийн сургуулиас бусад) болон номын сантай холбоотой гомдлыг барагдуулахад үүрэг хариуцлага хүлээн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тал дээр ажиллана.

◆ **Эрүүл мэнд ба хүн төвт үйлчилгээний газар**

Энэ нь анагаах ухаан, шүдний, сувилахуйн ухааны болон бусад эрүүл мэндийн чиглэлийн сургууль, “өвсний үндэс” буюу олон нийт дээр түшиглэсэн үйлчилгээний байгууллага, хөтөлбөрүүд, сургуулийн өмнөх болон өдөр өнжүүлэх хөтөлбөр гэх мэт эрүүл мэнд, халамж, нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага зэрэг эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хангамжтай холбоотой эрх зүй, зохицуулалтын асуудал дээр анхаарч ажиллана.

“Монголын хөгжлийн бэрхшээлийн тухай хууль”-ийг ХБИ-ийг хамгаалахад чиглэгдсэн хууль тогтоомжуудын хэрэгжилтийн хуультай уялдуулах

ХБИ-ийн эрхийг хамгаалах бүх эрх зүй, зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд хамгийн гол зүйл нь “Хууль хэрэгжилтийг хангах хууль”-ийг батлах явдал юм (энэ нь АНУ, Германы жишээ юм). Энэ хуулийг “Монголын хөгжлийн бэрхшээлийн тухай акт” гэж нэрлэж болно.

Агентлаг нь Монголын хөгжлийн бэрхшээлийн тухай актыг хэрэгжүүлэхийн тулд аливаа хүнийг шүүхэд хэрэгт татаж болох бөгөөд ялгаварлан гадуурхалтын нөхөн төлбөр болон нөхөн төлбөрийн торгууль төлүүлэх зэрэг шүүхийн шийдвэр гаргуулж болно.

◆ **Барилгын компаниудад тэтгэлэг/татварын урамшуулал олгох**

Орон байрыг илүү хүртээлтэй болгосны төлөө барилгын компаниуд, орон байр олгогчдыг урамшуулах хэрэгтэй. Ихэнхдээ орон байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрх тэгш хүртээхийг хүсдэг боловч хангалттай санхүүжилт байдаггүй. Тийм учраас Засгийн газар нь барилгын компанийн санаачлагыг эхнээс нь Барилгын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулснаар дэмжинэ.

◆ **Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж, хүртээлтэй байдал**

Зам тээврийн удирдлагын газар нь хотын автобус компаниудад үйл ажиллагааны гэрчилгээ олгохдоо тэдгээр нь Хөгжлийн бэрхшээлийн тухай хуулинд нийцэж буй эсэхийг шалгах хууль эрх зүй, зохицуулалтыг бий болгох;

Одоогийн эрх зүй, зохицуулалтыг биелүүлэхийн тулд дараах зөвлөмжийг санал болгож байна:

- Одоогийн хууль эрх зүй, зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулахдаа Конвенцитай нийцүүлэн хийнэ;
- ХБИ-ийн талаарх одоогийн эрх зүйн буюу зохицуулах бүтцэд гүнзгий дүн шинжилгээ хийх шаардлагатай (бусад орнуудын хууль эрх зүй, зохицуулалт);
- Сургалт, чадавхийг бэхжүүлэх, мэдлэг дээшлүүлэх, бусад орнуудын шилдэг туршлагаас судлах, тэр нь Монголд хэрэгжих боломжтой эсэхийг шалгах;
- Улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд конвенцийн зарчмуудыг тусган хэрэгжүүлэх
- Хэрэгжилтийн бүх шатанд ХБИ-н төлөөллийг оруулах хэрэгтэй.

V. ҮР ДҮНГ ХЭВЛЭН НИЙТЛҮҮЛЭХ

Монгол Улсад мэдээллийн хэрэгслүүд Хүний эрх болон хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтэд мэдээлэл дамжуулан энэ талаарх тэдний хандлагыг өөрчлөх гол хэрэгсэл болохынхоо хувьд илүү санаачлагатай ажиллаж чадна. Хурдацтай хөгжиж буй шинэ технологиуд нь харилцаа холбооны өртгийг бууруулж байна.

Монгол Улсад ХБИ-ийн талаар орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд ажилдаг бүх байгууллагууд, гишүүд НХХЯ-ны вебмастерт өөрсдийн хувь нэмэр болон материалаа авчирч өгөх бөгөөд вебсайт, чат, форум, интернэт дахь видео зэргийг ашиглан Хөгжлийн бэрхшээл ба Хүний эрх сэдвийн дагуу янз бүрийн асуудлаар хэлэлцэж ярилцаж болно.

Хөгжлийн бэрхшээлийн асуудлын тухай блог ба цахим хуудас

Дэлхий нийтийн харилцан туршлага солилцох арга болох орон нутаг, бүсийн, үндэсний болон олон улсын хурал зохион байгуулж, аюулгүй байдлыг дээшлүүлж, зөрчилдөөнийг багасгах арга замтай холбоотой асуудлаар нэг хот, бүс, улс оронд сурсан сургамж, хичээлээ бусадтай хуваалцах ёстой. Орон нутаг, олон улсын түвшинд бусад НҮБ-ын төрөлжсөн агентлагууд, ТББ-уудтай интернэтээр холбогдон харилцаа холбоогоо хөгжүүлэх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээл, хүний эрхийн тухай ойлголтыг илүү сайжруулах, ХБХ-ийн тухай олон нийтийн ойлголтыг өөрчлөх зорилгоор ХБХ-ийг нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралын бүхий л хүрээнд бодитойгоор оролцуулах гэсэн хоёр түвшний харилцаа холбоог санал болгож байна. Хөгжлийн бэрхшээл, хүний эрх, хүлээцтэй байдлын тухай үндэсний хэмжээний компанит ажил явуулах гурван гол боломж бол 12-р сарын 10-нд болдог Хүний эрхийн өдөр, 12-р сарын 3-нд болдог ХБИ-ийн олон улсын өдөр, 11-р сарын 16-нд болдог Хүлээцтэй байдлын олон улсын өдрийг тэмдэглэх явдал юм. Гарын авлага, блог, интернэтийн вэб хуудас зэрэг янз бүрийн эх үүсвэр ашиглан ХБХ-ийн тухай аймгуудад мэдээлж буй явдал бол хоёр дахь түвшний харилцаа холбооны дэвшил юм. Эдгээр нь “Монголд хэн хаана ХБХ-ийн төлөө юу хийж байна?”, “Яаж хийх вэ” зэрэг илүү практик заавар зөвлөгөөнд анхаарлаа хандуулах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Монгол Улс сүүлийн хориод жилд эдийн засгийн гайхамшигтай ахиц дэвшил гаргасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь Монголын нийгмээс гадуурхагдсан хэвээр, тэдний хандлага, чадварыг хязгаарлагдмал гэж үзсэн хэвээр байна. Одоо болтол зарим хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй байх нь өнгөрсөн хугацаанд хувь хүн болон түүний гэр бүлийнхний хийсэн муу үйлийн “шийтгэл” гэж үздэг бололтой.

Хүний эрх, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ажилгүйдэл, ядуурал болон хүртээмж зэрэг нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо хэрэглэдэг нийтлэг үгс юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох бололцоог хангахгүйгээр Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй. НХХЯ хичнээн сайн сайхан шийдвэр гаргасан ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүрээлэн буй орчин, нийгмийн ихэнх хэсэг нь тэдний хүрч чадахгүй, боломжгүй орон зай хэвээр байна. Ихэнх төсөл, санаачлагын эхлэл Улаанбаатар хотод тавигдаж эерэг үр нөлөө нь орон нутагт өргөжин тэлэх ёстой хэдий ч хамгийн том саад нь хүнд суртал, хэрэгжилтийн байдал муу зэрэг болж байна. Эдгээр асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэх нь Монголын нийгмийн бүх гол оролцогч талуудын цаашид идэвхтэй үргэлжлэх хүчин чармайлтаас зайлшгүй шалтгаалах болоод байна.

Монгол Улс өөрийн онцлог бүхий загвар боловсруулах шаардлагатай. Зарим оронд хэрэглэж буй арга техник Монголын ХБХ-ийн нөхцөл байдалд эерэг (эсвэл сөрөг) нөлөө үзүүлж болох ба гарсан амжилт ололт, үр дүнг эдийн засаг, нийгмийн өөр орчинд турших нь эрсдэлтэй байдаг. Гэсэн хэдий ч ХБХ-ийн нөхцөл байдал удахгүй сайжирна гэдэгт бид эргэлзэхгүй байна. Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм дараагийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг эерэгээр шийдэж чадна. Үүний тулд ХБХ-ийн асуудлыг дагнан хариуцсан газар байгуулж, НХХЯ, БСШУЯ, ЭМЯ-ны санхүүгийн болон хүний нөөц (хүчин чармайлт ...) болон экспертизийг зангидан ажиллах газар болгох нь зөв юм.

Энэ баримт бичиг нь дээрх зорилгод хүрэх гол гарын авлага болно гэдэгт итгэж байна.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ I: ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ II: ГОЛ БАРИМТ БИЧГҮҮД

- II.1 ХҮНИЙ ЭРХИЙН ЕРӨНХИЙ АКТ
- II.2 ХБИ-ИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН АКТ
- II.3 ХБИ-ИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН АКТ
- II.4 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ХБИ-ИЙН
ЭРХИЙН ТУХАЙ ГОЛ БАРИМТ БИЧГҮҮД
- II.5 НЭМЭЛТ ЛАВЛАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ III: МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СТАТИСТИК – ҮСХ 2009 ОН

МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС,
АЙМГААР (ҮСХ 2008, 2009 ОН)

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС (ҮСХ 2009 ОН)

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРЛӨӨР (ҮСХ 2009 ОН)

- ◆ 0-16 НАСНЫ ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ОЛДМОЛ ХБХ-ИЙН ТОО
- ◆ ХБХ-ИЙН ТОО (АЖЛЫН НАСНЫХАН)
- ◆ ОЛДМОЛ ХБХ (АЖЛЫН НАСНЫХАН)
- ◆ ХБХ-ИЙН ТОО (АЖЛЫН НАСНААС ДЭЭШ)
- ◆ ОЛДМОЛ ХБХ (АЖЛЫН НАСНААС ДЭЭШ)
- ◆ ХБИ-ИЙН ТОО (ХАРААГҮЙ)
- ◆ ОЛДМОЛ ХБХ (ХАРААГҮЙ)
- ◆ 0-16 НАСНЫ ХАРААГҮЙ ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ХАРААГҮЙ ОЛДМОЛ ХБХ
- ◆ ХБХ-ИЙН ТОО (СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ
БЭРХШЭЭЛТЭЙ)
- ◆ ОЛДМОЛ ХБХ(СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ БЭРХШЭЭЛТЭЙ)
- ◆ 0-16 НАСНЫ СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ОЛДМОЛ СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ ХБХ
- ◆ ТУЛАХ ЭРХТНИЙ ХБХ-ИЙН ТОО
- ◆ ТУЛАХ ЭРХТНИЙ ОЛДМОЛ ХБХ
- ◆ 0-16 НАСНЫ ТУЛАХ ЭРХТНИЙ ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ТУЛАХ ЭРХТНИЙ ОЛДМОЛ ХБХ
- ◆ ОЮУНЫ ХОМСДОЛЫН ХБХ-ИЙН ТОО

- ◆ ОЮУНЫ ХОМСДОЛЫН ОЛДМОЛ ӨВЧИНТЭЙ ХБХ
- ◆ 0-16 НАСНЫ ОЮУНЫ ХОМСДОЛЫН ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ОЛДМОЛ ОЮУНЫ ХОМСДОЛЫН ХБХ
- ◆ СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ХБХ-ИЙН ТОО
- ◆ ОЛДМОЛ СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ХБХ
- ◆ 0-16 НАСНЫ СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ОЛДМОЛ СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ХБХ
- ◆ ХАВСАРСАН ХБХ-ИЙН ТОО
- ◆ ОЛДМОЛ ХАВСАРСАН ХБХ
- ◆ 0-16 НАСНЫ ХАВСАРСАН ХБХ-ИЙН ТОО
- ◆ 0-16 НАСНЫ ОЛДМОЛ ХАВСАРСАН ХБХ
- ◆ БУСАД ТӨРЛИЙН ХБХ-ИЙН ТОО
- ◆ БУСАД ТӨРЛИЙН ОЛДМОЛ ХБХ

ХАВСРАЛТ I

Товчилсон үгсийн жагсаалт

БНБ	Бүх нийтийн боловсрол
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МСС	Мянганы сорилын сан
МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ҮХС	Үндэсний хөгжлийн стратеги
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ССЭСТ	Сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэхүй, эрүүл мэндийн ба сургалтын төв
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн/хүмүүс
ХБХЭК	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЯСХЭДБХТ	Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх төсөл

ХАВСРАЛТ II

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай албан ёсны гол баримтууд

II.1 Хүний эрхийн тухай ерөнхий акт

- НҮБ-ын тунхаг бичиг: 1945 оны 10-р сарын 24-нд хүчин төгөлдөр болсон
- 1948 оны 12-р сарын 10-ны өдрийн Ерөнхий ассемблейн 217А тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- 1989 оны 11-р сарын 20-ны өдрийн Ерөнхий ассемблейн А/44/25 тогтоолоор батлагдаж, 1990 оны 9-р сарын 2-нд хүчин төгөлдөр болсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц

II.2 ХБХ-ийн эрхийн тухай олон улсын акт

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тунхаглал, НҮБ-ын Ерөнхий ассемблейн тунхаглал, 1975 оны 12-р сарын 9
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, 2007 он
- МХЗ-ууд ба Хөгжлийн бэрхшээлийн тухай НҮБ-ын Ерөнхий ассемблейн тогтоол
- МХЗ-ыг ХБХ-ийн төлөө хэрэгжүүлэх нь А/КЕ8/64/131
- ХБХ-ийн төлөө хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлхий дахины хөтөлбөр, ХБХ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх замаар МХЗ-ыг ХБХ-ийн төлөө хэрэгжүүлэх нь А/КЕ8/63/150
- ХБХ-ийн тухай үйл ажиллагааны дэлхий дахины хөтөлбөр хэрэгжүүлэх: МХЗ-ыг ХБХ-ийн төлөө хэрэгжүүлэх А/КЕ8/62/127
- ХБХ-ийн тухай үйл ажиллагааны дэлхий дахины хөтөлбөр хэрэгжүүлэх: МХЗ-ыг ХБХ-ийн төлөө хэрэгжүүлэх А/КЕ8/60/131
- ХБХ-ийн тухай үйл ажиллагааны дэлхий дахины хөтөлбөр хэрэгжүүлэх А/КЕ8/58/132: 21-р зуунд бүх нийтийн төлөө нийгэм байгуулах
- ХБХ-т зориулсан адил тэгш боломжийн тухай стандарт дүрэм.

II.3 ХБХ-ийн сурч боловсрох эрхийн олон улсын акт

- Сурч боловсроход ялгаварлан гадуурхалтын эсрэг НҮБ-ын конвенц /1960/
- Бүх нийтийн боловсролын тухай олон улсын тунхаг /БНБ, 1990/
- Тусгай хэрэгцээний боловсролын тухай үйл ажиллагааны Саламанкийн мэдэгдэл ба хүрээ /1994/

- ЮНЕСКО /2001/ Оролцооны аргаар боловсрол олгох сургалтын менежерүүдэд зориулсан нэмэлт материал
- ЮНЕСКО /2005/ Бүх нийтийн сурч боловсрох оролцоог баталгаажуулах заавар
- ЮНЕСКО /2007/ Бага насны хүүхдийн анхаарал халамж, боловсролын үндэс суурь
- БНБ олон улсын хяналт үнэлгээний тайлан 2007
- ЮНЕСКО /2009/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах: бага насны хүүхдийн үүрэг хариуцлага ЮНЕСКО-ийн Бага насны хүүхдийн тухай бодлогын хураангуй
- ЮНЕСКО /2010/ Гадуурхагдаж буй хүмүүст хүрч ажиллах, Бүх нийтийн боловсролын олон улсын хяналт үнэлгээний тайлан 2010
- ЮНЕСКО Бангкок. Оролцоог хангасан боловсролд учрах саад бэрхшээл
- Дэлхийн банк /2004/ Оролцоог хангасан боловсрол: Бүх хүүхдэд зориулсан БНБ-ын стратеги
- БНБ-ын олон улсын тунхаг /Ёмтейн, Тайланд, 1990/: 3-р зүйл: Суурь боловсролоор бүх хүүхэд, залуус, насанд хүрэгчдийг хангах ёстой
- ХБХ-ийн адил тэгш боломжтой байх НҮБ-ын стандарт дүрэм /1993/: 6-р дүрэм: Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үе, насанд хүрэгчдэд бага, дунд, дээд боловсролыг нэгдмэл орчинд эзэмших боломж олгох зарчмыг хүлээн зөвшөөрнө.
- МХЗ-ууд 2000 /2015 онд хүрэх зорилт/: Зорилт 2: бүх нийтэд анхан шатны боловсрол эзэмшүүлэх

II.4 Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд ХБХ-ийн эрхийн тухай гол баримт бичгүүд

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16-4-р Зүйл: “Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 26.1-р Зүйл: “Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарагахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах”
- ХБИ-ий Нийгмийн хамгааллын тухай хуулийн 8-р Зүйл нь ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулдаг.
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р Зүйлд “25, түүнээс дээш

ажилтантай аж ахуйн нэгж байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” (111.1). “Аж ахуйн нэгж байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө” (111.2). “Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн, уг хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих араг хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” (111.4) гэж заасан байдаг.

- Хөдөлмөрийн тухай хуулийн 71.5-р Зүйлд ХБИ-ийн ажлын цагийг багасгах талаар заасан.
- Нийгмийн хамгааллын тухай хууль /2005.12.01/
- ХБИ-ий Нийгмийн хамгааллын тухай хууль /2008.01.15/
- Ахмад настны Нийгмийн хамгааллын тухай хууль /2008.01.15/
- Хөдөлмөрийн тухай хууль /1999 оны 5-р сар, 2008 оны 5-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан/
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001.04.19, 2008 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан/

II.5 Нэмэлт лавлах бичгүүдийн жагсаалт

- Монгол Улсад ХБИ-ийн эрхийг хэрэгжүүлэх тухай судалгааны тайлан, ХБИ-ийн ТББ-уудын Үндэсний Холбоо, 2009 он
- D.Zinamider, Research Papers of National Coalition of NGOs of the Rights of the Child, 2004
- Johnstone “Risk assessment in offenders with intellectual disability: the evidence base”. Journal of Intellectual Disability, 2002
- S. Peters: Inclusive education, an EFA Strategy for All Children 2004, World Bank
- UNESCAP, Asian and Pacific Decade of Disabled Persons 2003, United Nations. Workshop on improving Disability Measures for Policy use (23-26 September 2003) Bangkok, Thailand

ХАВСРАЛТ III

ХБХ-ийн талаарх статистик — ҮСХ 2009 он

Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, аймаг ба Улаанбаатар хотоор, Үндэсний статистикийн хороо, 2008, 2009 он


	Жил	2008	2009
Но	Нийт	76369	80796
1	Архангай	3391	3373
2	Баян-Өлгий	3796	4396
3	Баянхонгор	3161	3039
4	Булган	2258	2273
5	Говь-Алтай	1628	1582
6	Дорноговь	1595	1823
7	Дорнод	3578	3492
8	Дундговь	2012	1879
9	Завхан	3323	3477
10	Өвөрхангай	3604	4027
11	Өмнөговь	1000	1117
12	Сүхбаатар	1993	2220
13	Сэлэнгэ	3710	3837
14	Төв	2778	2694
15	Увс	2608	2732
16	Ховд	2667	2882
17	Хөвсгөл	4321	4510
18	Хэнтий	2801	3228
19	Дархан-Уул	2537	2569
20	Улаанбаатар	21062	22776
21	Орхон	2139	2420
22	Говьсүмбэр	407	450

ХБХ-ИЙН НИЙТ ТОО, 2009 ОН







ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС, АНГИЛЛААР НЬ




0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо
Нийт - 7809 хүн




0-16 насны олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо
Нийт - 2611 хүн









0-16 насны ХБХ-ийн тоо (хараагүй)
Нийт-1088 хүн





0-16 насны олдмол ХБХ (хараагүй)
Нийт-433 хүн




ХБХ-ийн тоо (сонсгол, хэл ярианы)
Нийт-9295 хүн







ХБХ-ийн тоо (тулах эрхтний)
Нийт-15501 хүн






Олдмол ХБХ (тулах эрхтний)
Нийт-10961 хүн




0-16 насны олдмол ХБХ-ийн тоо (тулах эрхтний)
Нийт-1797 хүн







0-16 насны ХБХ-ийн тоо (оюуны хомсдолын)
Нийт-1516 хүн




0-16 насны олдмол ХБХ (оюуны хомсдолын)
Нийт-367 хүн




ХБХ-ийн тоо (сэтгэцийн эмгэгийн)
Нийт-7670 хүн




Олдмол ХБХ (сэтгэцийн эмгэгийн)
Нийт-4225 хүн




0-16 насны ХБХ-ийн тоо (сэтгэцийн эмгэгийн)
Нийт-744 хүн



0-16 насны олдмол ХБХ (сэтгэцийн эмгэгийн)
Нийт-229 хүн




ХБХ-ийн тоо (хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй)
Нийт-8758 хүн




Олдмол ХБХ (хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй)
Нийт-6543 хүн




0-16 насны ХБХ-ийн тоо (хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй)
Нийт-869 хүн




0-16 насны олдмол ХБХ (хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй)
Нийт-341 хүн



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо (бусад төрлийн хөгжлийн бэрхшээл)
Нийт-21403 хүн



Олдмол ХБХ (бусад төрлийн хөгжлийн бэрхшээл)
Нийт-18535 хүн



Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв

ТЭМДЭГЛЭЛ:

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв

ТЭМДЭГЛЭЛ: